

## Батлах хамгаалах салбарт ёс зүйг бэхжүүлэх нь

Батлан хамгаалах салбар дахь авлигын асуудалд парламентын гишүүд яагаад анхаарал хандуулах ёстой вэ?

Батлан хамгаалах салбар авлигад өртөмтгий байдгийн шалтгаан?

Батлан хамгаалах төсвийн зарлагын төрлүүдийн талаар парламентын гишүүн юу мэдэх ёстой вэ?

Хүний нөөцийн удирдлага дахь авлигын эрсдлүүд

Үйл ажиллагаа, техникийн засвар үйлчилгээн дэх авлигын эрсдлүүд

Зэвсэг техникийн худалдан авалт дахь авлигын эрсдлүүд

Нөхөн төлбөрийн хэлцэл дэх авлигын эрсдлүүд

Зэвсэг техникийн зориулалтыг өөрчлөн шинэчлэх явц дахь авлигын эрсдлүүд

Ёс зүйг бэхжүүлэхэд оролцогч талууд

Батлан хамгаалах салбарт ёс зүйг бэхжүүлэх олон улсын хэм хэмжээ, тэргүүний туршлага

Батлан хамгаалах төсөвтэй холбоотой мэдээллийн хараат бус ямар эх сурвалжууд байдаг вэ?

## Батлан хамгаалах салбар дахь авлигын асуудалд парламентын гишүүд яагаад анхаарал хандуулах ёстой вэ?

Ихэнх улс оронд ард иргэд зэвсэгт хүчиндээ итгэдэг. Олон нийтийн санал асуулгаас үзэхэд, нийгэмд цэргийнхэн хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, улс төрийн намууд, парламентаас ч илүү хүндэтгэл хүлээдэг бөгөөд зөвхөн шашны болон төрийн бус байгуулага л өмнө нь ордог байна. Гэсэн хэдий ч батлан хамгаалах нь төрийн үйл ажиллагааны хамгийн авлигажсан салбарын нэг төдийгүй, үүгээрээ уул уурхай, дэд бүтцийн томоохон төслүүдтэй өрсөлдөхүйц хэмжээнд байдгийг олон судалгаа харуулдаг (тухайбал, Транспаренси Интернэшнл ОУБ-аас гаргасан "Дэлхийн авлигын барометр 2010" индекс).

Батлан хамгаалах салбарт шударга ёсыг бий болгож төлөвшүүлэх нь аливаа улс орны хууль тогтоогчдын хувьд чухал гэдэг нь дараах учир шалтгаантай холбоотой.

### Тодруулга 1. Нэр томъёо ба үзэл баримтлал

**Ёс зүй** гэдэг нь хувь хүн өөрийн хүлээсэн үүрэг хариуцлагыг үнэнчээр, мэргэжлийн өндөр төвшинд гүйцэтгэхийг хэлнэ. Аливаа үйл явц зориулалтынхаа дагуу, өөрийн хамаарч буй илүү өргөн тогтолцооны хүрээнд өрнөж байгаа бол ёс зүйн хэм хэмжээний хүрээнд явагдаж байна гэсэн үг. Байгууллагын үйл ажиллагаа тайлан тооцоотой, мэргэжлийн зохих төвшинд явагдаж, хөрөнгө нөөцийг шударга бус, хувийн явцуу ашиг сонирхолд ашиглаагүй бол тус байгууллагад ёс зүй тогтсон байна. Ёс зүйтэй байдлыг ихэвчлэн аудит болон шалгалтаар тогтоодог.

**Авлига** гэж албан тушаалаа хувийнхаа ашиг сонирхолд урвуулан ашиглахыг хэлдэг. Батлан хамгаалах салбар дахь авлига нь хээл хахууль, шан харамж, өрсөлдөгчгүй гэрээ хэлцэл, албан хаагчдын цалингийн цэсийг бүдлиантуулах, төсвийг зориулалтын бусаар зарцуулах, цэргийн өмч хөрөнгийг төсвөөс гадуур ашиг олоход зарцуулах зэрэг олон хэлбэр төрөлтэй байж болно.

**Ашиг сонирхлын зөрчил** нь тухайн албан тушаалтан хувийн тодорхой ашиг сонирхлыг албан үүргээсээ дээгүүр тавих үед үүснэ. Зарим оронд ашиг сонирхлын зөрчилд худалдан авалтын гэрээнээс зөвхөн одоо цагт бус ирээдүйд ч ашиг хонжоо хүртэх эсвэл төрийн алба хашихаа больсоны дараа тухайн ханган нийлүүлэгчид ажил орох, тодорхой хугацааны туршид өөр бусад хэлбэрээр шан халамж авах зэргийг хамруулдаг.

**Эдийн засгийн гэмт хэрэг дэх рациональ үйлдлийн онолд** авлигыг авч үзэхдээ хууль зөрчин олж авах ашиг хонжоог баригдаж, ноцтой ял шийтгэл хүлээх эрсдэлтэй харьцуулан хувь хүний хийх рациональ сонголт талаас нь авч үзсэн байдаг. Энэ үүднээс авч үзвэл, авлигыг зогсоох хоёр хүчин зүйл байх бөгөөд энэ нь үндэсний соёл, хувь хүний ёс зүйгээр тодорхойлогддог "ёс суртахууны дарамт" ба хууль тогтоомжоор тодорхойлогддог "хүлээгдэж буй ял шийтгэл" юм.



# DCAF

a centre for security,  
development and  
the rule of law

Энэхүү товч мэдээлэл нь батлан хамгаалах салбарт ёс зүйг бэхжүүлэх, авлигын эрсдлийг бууруулах суурь ойлголтууд, стратеги, тэргүүний туршлагаудыг танилцуулах зорилготой болно.

Юуны өмнө, батлан хамгаалах салбар дахь авлига нь нийгмийн бусад салбарт өндөр үнэтэй тусч, улсын төсвөөс боловсрол, эрүүл мэнд, инноваци, хөгжил дэвшилд зарцуулагдаж болох байсан хөрөнгийг сорж авдаг.

Хоёрдугаарт, авлига нь үндэсний батлан хамгаалах чадавхид сөргөөр нөлөөлж, цэргийн үйл ажиллагааны үр нөлөөг бууруулдаг. Энэ нь бие бүрэлдэхүүний аюулгүй байдал, бэлтгэл сургуулилт, байлдааны нөхцөл, цэргийн албан хаагчдын ёс суртахууны байдалд муугаар нөлөөлнө. Түүгээр ч зогсохгүй, авлигажсан батлан хамгаалах салбар нь тухайн орны улс төр, эдийн засаг “гэмт хэрэгжих”-д ихээхэн түлхэц өгдөг бөгөөд ингэснээрээ эргээд үндэсний аюулгүй байдалд занал учруулна. Батлан хамгаалах салбарт ёс зүй үгүй бол зохион байгуулалттай гэмт хэргийн болон террорист бүлэглэлүүд, гадны тагнуулын алба, явцуу бизнесийн бүлэглэлд үндэсний чухал мэдээ мэдээлэл, ноу-хау, аюултай бодис, зэвсгийн технологи алдах боломж бий болдог.

Эцэст нь, батлан хамгаалах салбар дахь авлига төрд итгэх иргэдийн итгэлийг сулруулдаг. Нэг үгээр хэлбэл, зэвсэгт хүчинд итгэх итгэл алдагдаж, үндэсний батлан хамгаалах бэлэн байдал, нэр хүнд унана.

#### Тодруулга 2. Болгарын батлан хамгаалах салбар дахь авлигын дуулианы үр дагавар

Тус улсын батлан хамгаалахын салбарт шил дараалан гарсан авлигын дуулианы улмаас цэргийнхний нэр хүнд ихээхэн унасан. 2009 онд батлан хамгаалахын хэд хэдэн удирдах албан тушаалтнуудтай холбоотой мөрдөн байцаалт явагдаж, албан тушаалаа урвуулан ашигласан болон авлигатай холбоотой ял ногдуулсан. Үүнээс үүдэлтэй олон нийтийн дарамт шахалтын улмаас батлан хамгаалахын төсөв ихээхэн танагдаж, бие бүрэлдэхүүний нэр хүнд, сэтгэл санаа уналтад ороод байв. Харин энэ хэрэгт холбоотойгоор авсан хариу арга хэмжээ нь Болгарын аюулгүй байдал, батлан хамгаалахын салбарт эрс өөрчлөлт авчирсан бөгөөд өнөөдөр тус улс НАТО-ын Шударга ёсны итгэлцлийн сангийн тэргүүлэгч улс болоод байна.

Шударга ёсыг бэхжүүлэх ба авлигатай тэмцэх нь нэг зоосны хоёр тал. Гэхдээ шударга байдал тогтоох нь илүү эерэг бөгөөд идэвхтэй хандлага юм.

## Батлан хамгаалах салбар дахь авлигын асуудалд парламентын гишүүд яагаад анхаарал хандуулах ёстой вэ?

Олон оронд батлан хамгаалах салбар төрийн хамгийн том ажил олгогч байдаг ба уг тогтолцооны төвд зэвсэгт хүчин оршиж, өөрийн гэсэн боловсрол, эрүүл мэнд, шүүх прокурорын бүтцээс гадна ар тал хангалт, захиргааны томоохон дэд бүтэцтэй байдаг.

**Батлан хамгаалах төсөв** нь улсын төсвийн хамгийн том зүйл заалтын нэг байх нь их. Улсын төсөвт батлан хамгаалах төсвийн эзлэх хувь хэмжээ Австри, Бельги, Унгар зэрэг орнуудад 2-3%, Франц, Герман, Грек зэрэг орнуудад 4.5% хүртэл байдаг бол Орос, Энэтхэг, АНУ зэрэг орнуудад 16-18% байдаг. Батлан хамгаалах төсөв нь зөвхөн улсын төсвийн төдийгүй ДНБ-ий томоохон хувийг эзэлдэг ба Японд 1%, АНУ болон ОХУ-д 4.5% байдаг бол Саудын Арабт 9%-д хүрдэг байна.

Улс	Батлан хамгаалах зардал (2013)
Албани	1.5%
Босни Герцеговин	1.4%
Болгар	1.5%
Хорват	1.7%
Македон	1.4%
Молдав	0.3%
Монтенегро	1.9%
Румын	1.3%
Серб	2.2%
Словен	1.2%

Эх сурвалж: World Bank <http://data.world-bank.org/indicator/MS.MIL.XPND.GD.ZS>

Авлигаар олох ашиг хонжоонд дараах хүчин зүйлс нөлөөлнө. Үүнд:

- оролцож буй төрийн албан хаагчийн мэдэлд буй нөөцийн хэмжээ,
- уг албан хаагчийн албан тушаалд хамаарах эрх мэдлийн хэмжээ,
- батлан хамгаалах салбар дахь ил тод, хариуцлагатай байдлын төвшин.

**Нууцлал.** “Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг хамгаалах” үүднээс нууцлах нь тус салбар дахь ил тод байдлын хамгийн том дайсан мөн. Ингэснээр хөндлөнгийн үр дүнтэй хяналт явуулах аливаа боломжийг нэг мөр хаадаг. Мөн батлан хамгаалахын зориулалттай худалдан авалтад оролцогчдын тоог хязгаарласнаар (тэр ч байтугай ганц эх үүсвэрээс худалдан авалт хийхэд хүргэснээр) өрсөлдөөнийг боогдуулж, үнэ болон гэрээний нөхцөлд нийлүүлэгч дүр мэдэн нөлөөлөх боломжийг нээнэ.

**Яаралтай байдал.** Үйл ажиллагааны болон батлан хамгаалах хэрэгцээг нэн яаралтай хангах үүднээс дүрэм журмыг хялбаршуулах, тэр ч атугаа үл хэрэгсэн сонгон шалгаруулалт нээлттэй, өрсөлдөөнтэй байх зарчмыг орхигдуулах явдал гарах нь бий. “Яаралтай” хийх шаардлага нь ялангуяа “нууц” хэмээх хаалттай хослосон бол ил тод бус, дур зоргоороо шийдвэр гарах боломжийг нэмэгдүүлж, нийлүүлэгч этгээд үнээ үндэслэлгүй нэмэх боломж бүрддэг.

**Популист уриа лоозон.** Популист уриа лоозон авлигыг нуун дарагдуулах нэг арга байж болох юм. “Ард олныг ажил төрөлтэй байлгахын тулд” батлан хамгаалахын бүтээгдэхүүн ба үйлчилгээг “дотоодоос худалдан авах” уриалгыг хаалттай, өрсөлдөөнт бус гэрээ хэлцлийг зөвтгөхөд ашиглах явдал элбэг тохиолддог ба сөрөг үр дагавар нь янз бүр байна. Жишээлбэл, чанаргүй бараа, үйлчилгээг өндөр үнээр авах. Түүнчлэн, дотоодын ханган нийлүүлэгчдэд тал зассан бодлого нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, шинэ технологи нэвтрэхэд сөргөөр нөлөөлж, цөөн өрсөлдөгч бүхий, авлигачдад ээлтэй орчинг бүрдүүлдэг байна.

## Батлан хамгаалах салбар дахь авлигын асуудалд парламентын гишүүд яагаад анхаарал хандуулах ёстой вэ?

Батлан хамгаалах төсвийн зарлага ихэвчлэн дараах дөрвөн төрөлд хуваагддаг. Үүнд:

- хүний нөөцийн удирдлага
- ажиллагаа болон нөхөн хангалт
- зэвсэг техник худалдан авах ажиллагаа, барилга
- судалгаа, төсөл

Зарлагын төрөл тус бүр нь авлигын өвөрмөц эрсдэлтэй бөгөөд авлигатай тэмцэхэд учирч болох өвөрмөц бэрхшээлтэй.

Хүснэгт 2. Зүүн өмнөд Европын орнууд дахь БХ төсвийн задаргаа			
<b>Албани (2011)</b>		<b>Босни-Герцеговин (2010)</b>	
Бие бүрэлдэхүүн:	68.33%	Бие бүрэлдэхүүн:	79.32%
Үйл ажиллагаа:	17.16%	Үйл ажиллагаа:	19.29%
Худалдан авалт:	14.51%	Худалдан авалт:	1.39%
<b>Болгар (2010)</b>		<b>Хорват (2011)</b>	
Бие бүрэлдэхүүн:	53.86%	Бие бүрэлдэхүүн:	62.82%
Үйл ажиллагаа:	27.86%	Үйл ажиллагаа:	20.12%
Худалдан авалт:	18.20%	Худалдан авалт:	17.06%
С ба Т:	0.08%		
<b>Македон (2010)</b>		<b>Молдав (2010)</b>	
Бие бүрэлдэхүүн:	70.52%	Бие бүрэлдэхүүн:	74.61%
Үйл ажиллагаа:	18.58%	Бие бүрэлдэхүүн:	24.41%
Худалдан авалт:	10.90%	Үйл ажиллагаа:	0.10%
		Худалдан авалт:	
<b>Montenegro (2010)</b>		<b>Румын (2011)</b>	
Бие бүрэлдэхүүн:	69.99%	Бие бүрэлдэхүүн:	71.06%
Үйл ажиллагаа:	23.52%	Үйл ажиллагаа:	15.63%
Худалдан авалт:	6.48%	Худалдан авалт:	13.14%
		С ба Х:	0.16%
<b>Серб (2011)</b>		<b>Словен (2011)</b>	
Бие бүрэлдэхүүн:	71.76%	Бие бүрэлдэхүүн:	8.15%
Үйл ажиллагаа:	22.10%	Үйл ажиллагаа:	1.45%
Худалдан авалт:	6.08%	Худалдан авалт:	10.18%
С ба Т:	0.06%	С ба Т:	0.20%
Эх сурвалж: Цэргийн зардлын талаарх НҮБ-ын тайлан ( <a href="https://milex.un.org/">https://milex.un.org/</a> )			

Зүүн өмнөд Европын орнуудад бие бүрэлдэхүүнтэй холбоотой зардал нь батлан хамгаалах зардлын хамгийн том хэсгийг эзэлдэг тул уг асуудал нь ёс журмыг төлөвшүүлэх хүчин чармайлтын гол талбар болдог байна.

## Хүний нөөцийн удирдлага дахь авлигын эрсдлүүд

Хүний нөөцийн удирдлага дахь авлига нь дарамталж мөнгө авах, хулгай, хээл хахууль, авлигын сүлжээг бий болгох зэрэг олон төрөл, хэлбэртэй байж болно. Тогтоосон бодлого, дүрэм журмыг хатуу баримтлаагүй боловсон хүчний ямар ч шийдвэр, үйл ажиллагаа үүнд хүргэж болно. Тухайлбал:

- цэргийн албанаас зайлсхийх (авилгач албан тушаалтан, эмч, цэрэг татлагын төвийн зааварлагчдын сүлжээ)

- офицер бэлтгэх хөтөлбөр, дамжаанд шалгалтад тэнцэхгүй этгээдийг элсүүлэх
- зохих үндэслэлгүйгээр томилгоо хийх, цол нэмэх, албан тушаал дэвшүүлэх
- гадаад томилгоог шударга бусаар гаргах (хилийн чанад дахь сургалт, энхийг сахиулах ажиллагаа г.м)
- хөдөлмөрийн хөлс, нийгмийн халамжийн (байр орон сууц, хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээ, дүрэмт хувцас, амралт чөлөө г.м) тэгш бус хуваарилалт

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг баталгаажуулахад хүндрэл учруулдаг хэд хэдэн хүчин зүйл бий. Цэрэг татлага, томилгоо нь нийт тогтолцоог хамарсан хэвтээ тэнхлэгээр хэрэгждэг бол илтгэн тайлагнах ажиллагаа нь командлалын босоо шатлалын дагуу явагдана. Цэргийн анги салбар ба төв удирдлагын хоорондох зохион байгуулалтын ялгаа зааг, мөн үүн дээр цэргийн албаны ёс заншлын бичигдээгүй хэм хэмжээ, уламжлал нэмэгддэг тул “шүгэл үлээх” буюу асуудал сөхөж тавих хүн бараг гардаггүй. Тиймээс үнэн бодит мэдээлэл олж авахад тийм ч амар биш.

## Парламентын гишүүд хүний нөөцийн удирдлагын чиглэлээр юу хийх боломжтой вэ?

- Зэвсэгт хүчний эрх зүйн байдал, цэрэг татлагын нөхцөл, сургалт боловсрол, албан тушаал дэвших болон хүний эрх, ажлын нөхцөл зэргийг нарийн тодорхой зохицуулсан хуулийн орчинг бий болгох
- Дээд төвшний томилгоог парламент батлах эсвэл баталгаажуулах
- Хүний нөөцийн бодлого, түүний хэрэгжилттэй холбогдуулан Батлан хамгаалах яамнаас асуулт асууж, тайлан шаардах
- Зөрчил, ялгаварлан гадуурхалт, удирдлагын зүй бус үйлдэл зэргийн талаар зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнээс ирүүлсэн өргөдөл гомдлын асуудлаар Хүний эрхийн комиссоос мэдээлэл авч, зөвлөлдөж байх
- Герман, Босни Герцеговин зэрэг оронд байдаг Цэргийн асуудал эрхэлсэн парламентын комиссартай ижил Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий бүтцийг тусгайлан байгуулах боломжийг судлах

## Үйл ажиллагаа, нөхөн хангалт дахь авлигын эрсдлүүд

Аливаа улсын батлан хамгаалах нийт төсвийн 20 орчим хувийг операц, нөхөн хангалтын зардал эзэлдэг. Энэ ангилалд бие бүрэлдэхүүний тайван цагийн сургалт, үйл ажиллагааны бэлтгэл, хамтарсан сургууль, олон улсын энхийн ажиллагаанд оролцох зэрэг зардал багтдаг.

Энхийн ажиллагаанд цэрэг оролцуулах шийдвэрийг ихэвчлэн давчуу хугацаанд гаргах шаардлагатай болдог бөгөөд ийм ажиллагаатай холбоотой худалдан авах ажиллагааг хялбаршуулан өрсөлдөөнөөс зайлсхийх нь бий. Ийм үед үйл ажиллагааны харилцан уялдаа, бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг гол болгож, зардал мөнгөний асуудлыг хоёрдугаарт тавих нь түгээмэл.

Түүнчлэн ийм ажиллагаанд оролцогчдын сонгон шалгаруулалт замбраагүй, хаалттай явагдах нь их.

Олон улсын ажиллагаанд оролцогчдын цалин энгийн үеийнхээс хэд дахин илүү байдаг. Тиймээс цэргийн алба хаагчид, офицерууд олон улсын ажиллагаанд оролцохын тулд зүй бус нөлөөлөл ашиглах, хээл хахууль өгөх, хариу ашиг тус амлах зэрэг тохиолдол гарах нь бий. Зарим шинжээчид энхийг сахиулах ажиллагаанд тусгайлан эмхэлж цуглуулсан баг биш, харин байнгын ажиллагаатай нэгж оролцуулах нь зардал хэмнэж, нэмэлт бэлтгэл бага шаардах давуу талтай гэж зөвлөдөг байна.

Дараах гурван замаар батлан хамгаалах үйл ажиллагаа хувийн хэвшлээс хамаарах нь улам бүр нэмэгдэж байна. Үүнд:

1. **Аутсорсинг** буюу байгууллагын үйл ажиллагааны аль нэг салбарыг тухайн чиглэлээр мэргэшсэн ханган нийлүүлэгчид гэрээгээр шилжүүлэх.
2. **Хувьчлал** буюу төрийн мэдэлд буй өмч, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг хувийн хэвшилд худалдаж шилжүүлэх.
3. **Төр, хувийн хэвшлийн түншлэл** буюу хувийн хэвшлээс батлан хамгаалах төсөл эсвэл үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийж, нөөц бололцоо, мэдлэг мэргэшлээс гадна эрсдэл, ашгаа хуваалцах.

Эдгээр зохицуулалтыг ашигласнаар батлан хамгаалах хүчний үр нөлөөг нэмэгдүүлэх бүрэн боломжтой. Гэхдээ ёс зүйн хүчирхэг манлайлал, институци, хяналтын тогтолцоогүйгээр дээрх зохицуулалт хээл хахууль, хууль бус ажиллагааны замыг нээх эрсдэлтэй. Үүний зэрэгцээ улс төрийн хийгээд хүнд суртлын механизмыг батлан хамгаалах салбарт бус харин хувийн ашиг сонирхолд ашигтай шийдлийг сонгоход хүргэх зорилгоор хувийн хэвшлийн зүгээс хууль ёсны лобби явуулах магадлал бий.

### Тодруулга 3. Хувьчлалын явц дахь авлигын шинж тэмдгүүд

- Сонгуулийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт дутуу дулимаг байгаагаас ихэвчлэн үүдэлтэйгээр парламент хувийн хэвшлийн зүй бус нөлөөнд автах
- Төрийн удирдлагын үйл ажиллагаанд ил тод байдал дутмаг байх буюу өмч хувьчлалын стратеги, бодлого, шийдвэр гаргалтын талаарх мэдээлэл олон нийтэд хаалттай байх
- Өмч хувьчлалын хөтөлбөрүүдэд оролцож буй улс төрч, албан тушаалтнуудад хүлээлгэх хариуцлага, хяналтын тогтолцоо байхгүй байх
- Авлига авсан нь тогтоогдсон буюу сэжиглэгдэж буй, эсбөгөөс илт ашиг сонирхлын зөрчилтэй улс төрч, албан тушаалтнуудад хүлээлгэх эрүүгийн, иргэний, сахилгын арга хэмжээ байхгүй байх
- Албан хаагчид, иргэд авилгын талаар нууцаар буюу нэрээ нууцлан гомдол гаргах боломж байхгүй байх
- Өмч хувьчлалтай холбоотой шийдвэр гаргах эрх бүхий улс төрч, албан тушаалтнууд хөрөнгө орлого, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдүүлэх үүрэг хуулиар хүлээгээгүй байх
- Хэвлэл мэдээллийн салбар нь улс төрийн сонирхолд үйлчилдэг, сул дорой байх

Сүүлийн үед улам олширч байгаа цэргийн зориулалттай хувийн компаниудыг хилийн чанад дахь ажиллагаа, энхийг сахиулах болон тогтвортой байдлын ажиллагаанд гэрээгээр оролцуулах болсон нь санаа зовних нэг гол асуудал болж байна. Эдгээр ажиллагаанд оролцогчдыг сонгон шалгаруулах үйл явц ихэвчлэн хаалттай байдаг тул танил талаа илүүд үзэх, хээл хахууль, авлига авах боломж бий болдог.

Өнөөдрийг хүртэл гэрээгээр ажиллагсдыг үнэлэх, бүртгэх, лицензжүүлэхтэй холбоотой олон улсын тогтолцоо буюу мэргэжлийн стандартын нэгдмэл жишиг байхгүй байна. Гэсэн ч ийм тогтолцоог бий болгоход чиглэсэн зарим алхмууд хийгдсэн. Тухайлбал, *Цэргийн болон аюулгүй байдлын хувийн хэвшлийн байгууллагуудын талаарх Монтрёгийн бичиг баримт (2008)* нь цэргийн болон аюулгүй байдлын хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаанд олон улсын хууль тогтоомж хэрхэн үйлчлэх талаар цоо шинэ асуудлыг хөнджээ. *Аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын ёс зүйн дүрэм* нь нарийн төвөгтэй орчинд үйл ажиллагаа явуулж буй тэдгээр байгууллагын баримтлах олон улсын хэм хэмжээг тодорхой болгохын зэрэгцээ тэдгээрт тавих хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулахад чиглэсэн олон талт санаачилга юм.

### Парламентын гишүүд ажиллагаа болон нөхөн хангалтын чиглэлээр юу хийж чадах вэ?

- Энхийн болон хямралт цагийн аль алинд авлигатай тэмцэх хууль журам гаргаж мөрдүүлэх
- Анги салбарын төвшинд хяналтыг хэрэгжүүлэх зааварчилга, механизмыг Батлан хамгаалах яамны зүгээс бий болгоход дөхөм үзүүлэх
- Үүсч болох авлигын бүх асуудлыг тодорхойлж, эдгээр нөхцөлд дагаж мөрдөх ёстой хэм хэмжээг батлан хамгаалах салбарын нийт бие бүрэлдэхүүн мэддэг байхад анхаарах
- Онц байдал үүссэн болон энхийг дэмжих ажиллагааны хүрээнд түргэвчилсэн горимоор хийсэн худалдан авалтын бүх ажиллагааг хянан үзэж, эдгээр нөхцлийг авлигын эх үүсвэр болгон ашиглах боломжийг хаах
- Илүүдэл өмч хөрөнгө зарж борлуулснаас олсон орлогын тооцоо бүртгэлийг хянаж, орлогыг аль байгууллага хүлээж авсан, ямар зориулалтаар ашиглах ёстой зэрэгт анхаарал хандуулах

### Зэвсэг техникийн худалдан авалт дахь авлигын эрсдлүүд

Зэвсэг техникийн худалдан авалт гэсэн ойлголт нь дараах тодорхой үйл ажиллагааг хамардаг. Үүнд:

1. Илүү хөгжингүй зэвсгийн систем нэвтрүүлэх замаар батлан хамгаалах чадавхийг шинэ түвшинд гаргах.
2. Сэлбэг, шатахуун, ложистикийн үйлчилгээ зэргийг хангах замаар батлан хамгаалах өнөөгийн чадавхаа хадгалах.

Зэвсэг техникийн худалдан авалт нь дараах шалтгааны улмаас авлигад өртөх магадлал хамгийн өндөрт тооцогддог. Юуны өмнө, салбарын хэмжээ том учир хүнс, шатахуун, дүрэмт хувцас зэрэг энгийн бүтээгдэхүүний нийлүүлэлт ч их мөнгөөр хэмжигддэг. Харин тусгай, өндөр хөгжсөн технологийн хувьд боломжит нийлүүлэгчдийн тоо хязгаарлагдмал байх талтай.

Үүнээс гадна, үндэсний аюулгүй байдлын хэрэгцээ шаардлагын үүднээс худалдан авалтын бусад хувилбарыг хязгаарласнаар, гэрээ хэлэлцээрт нөлөөлөх хэт их эрх мэдлийг ханган нийлүүлэгчдэд олгодог байна. Эцэст нь, зардалтай холбоотой тоо баримт олж авахад бэрх, хагас дутуу, эсбөгөөс огт байдаггүй тул батлан хамгаалах хэрэгцээ шаардлагыг худалдан авалттай шууд холбоход төвөгтэй.

Зэвсэг техникийн худалдан авалт дахь авлига нь нэг бол сонгон шалгаруулалтад оролцогч (сонгон шалгаруулалтын үр дүнд нөлөөлөхийн тулд хууль бус шан харамж санал болгох)-ийн талаас эсвэл төрийн албан тушаалтан (сонгон шалгаруулалтын үр дүнд нөлөөлөхөөр амлаж хууль бус шан харамж нэхэх, дарамт үзүүлэх г.м)-ы талаас эхтэй байдаг. Иймд, худалдан авалт дахь авлигыг бууруулахын тулд худалдан авах үйл явцын ёс зүйг бэхжүүлэх хүчин чармайлтыг оролцогч байгууллага болон хүмүүсийн үйлдэл, шийдвэр гаргах үйл явцад чиглүүлэн гаргах ёстой.

### 1. Оролцогч байгууллагуудын ёс зүй

Худалдан авалтын гэрээний хоёр тал буюу эрэлт ба нийлүүлэлтийн аль алинд ёс зүйг бий болгож, бэхжүүлэхийг эрмэлзэх нь чухал. Худалдан авагч тал буюу Батлан хамгаалах яам, цэргийн бусад байгууллагын хувьд эрх мэдлийн, нэн ялангуяа шийдвэр гаргах ба хяналтын чиг үүрэг бүхий талуудын эрх мэдлийг нарийн заагласан байх учиртай.

#### Тодруулга 4. Оролцогч байгууллагуудын ёс зүйг бэхжүүлэх

##### Батлан хамгаалах салбарын ёс зүйн гэрээ

Худалдан авалтын сонгон шалгаруулалт болон гэрээ байгуулах үе шатанд засгийн газраас авлигатай тэмцэх арга хэрэгсэл болгон ашиглахад зориулж Ёс зүйн гэрээ гэгчийг Транспаренси интернэшнл байгууллага 1990-ээд онд боловруулсан. Уг Ёс зүйн гэрээ бол сонгон шалгаруулалтад оролцогч болон худалдан авагч талууд нь тухайн худалдан авалтын үед авлигаас ангид байх талаар үүрэг хүлээх тухай гэрээ юм. Цаашилбал, сонгон шалгаруулалтад оролцох санал ирүүлсний дараа тодорхой хугацааны туршид төрийн албан тушаалтан, тэдний ойрын хамаатан садан тухайн компанид ажил эрхлэхийг Ёс зүйн гэрээний дагуу хориглох бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгч, зуучлагч нарын талаарх мэдээллийг ил болгох ёстой. Эл гэрээний ил тод байдлыг хангах үүднээс бие даасан хянагч эсвэл тусгай баг томилох ба тэд бүх үүлзалт хуралд оролцох, баримт бичигтэй танилцах эрхтэй байна. Өнөөгийн байдлаар Хорват, Энэтхэг, Польш, Их Британи зэрэг нийт 15 орон батлан хамгаалахын худалдан авалтын томоохон гэрээ хэлцлүүддээ ийм гэрээг нэвтрүүлээд байна.

##### АНУ-ын Батлан хамгаалах аж үйлдвэрийн санаачилга

АНУ-ын батлах хамгаалахын томоохон компаниуд хамтран Батлах хамгаалах аж үйлдвэрийн санаачилга (БХАУС)-ыг байгуулсан бөгөөд гишүүн компаниуд тус тусын ёс зүйн хөтөлбөр, практик ажиллагааны талаар жил бүр дэлгэрэнгүй маягт бөглөж ирүүлдэг. Эдгээр хариуцлыг нэгтгэн БХАУС-ын жил тутмын Хариуцлагын тайланг гаргадаг байна. БХАУС-ын гишүүн компани бүгд ёс зүйн дүрэм, ёс зүйн алба, шүгэл үлээгчдэд зориулсан шууд утас, ажилтнуудад зориулсан ёс зүйн сургалт зэргийг нэвтрүүлсэн байдаг.

Нийлүүлэгчдийн хувьд, сүүлийн жилүүдэд батлан хамгаалах салбарт шил дараалан авлигын дуулиан гарч, батлан хамгаалахын гэрээт аж ахуйн нэгжүүдэд итгэх олон нийтийн итгэл ихэд буураад байна. Шаардлага хангасан оролцогчдын жагсаалтад багтах, эсбөгөөс өрсөлдөгчдийнхөө тоог хязгаарлах зорилгоор тухайн компани шан харамж өгөх тохиолдол гарах магадлалтай. Ийм үйлдэл хийсэн компаниуд цаашилсаар зөвхөн тухайн сонгон шалгаруулалтад шалгараад зогсохгүй мөн цаашид төрөөс татаас авах, монополь эрх эдлэх, дүрэм журмыг өөртөө тохируулж өөрчлөхийг хүсдэг нь тодорхой.

Өөрсдийг нь хэзээ нэгэн цагт залгих хээл хахуулийн энэхүү сүлжээг таслан зогсооход нийлүүлэгчид манлайлах үүрэгтэй оролцох ёстой гэж үздэг.

### 2. Хувь хүний ёс зүй

Худалдан авалтын ажиллагаанд оролцож буй хувь хүмүүс ёс зүйгүй бол авлигын эсрэг ямар ч арга хэмжээ амжилтад хүрэхгүй. Хувь хүний төвшинд авлигын эрсдлийг бууруулахын тулд улс орнууд “хатуу” ба “зөөлөн” арга хэмжээг хослуулан хэрэглэдэг.

Хатуу арга хэмжээ нь ашиг сонирхлын зөрчил, авлигын хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэлбэртэй байна. Ингэхдээ зөвхөн тухайн худалдан авалтын ажиллагаа үргэлжилсэн хугацаа бус, түүнээс өмнөх хийгээд хойшхи хугацааг ч мөн хамааруулдаг. Өөрөөр хэлбэл, төрийн болон цэргийн албан тушаалтнууд өмнө нь тухайн ханган нийлүүлэгчтэй холбоо сүлбээтэй байсан эсвэл төрийн болон цэргийн албанаас гарсны дараа тэр компанид ажиллах зэргээс үүдэлтэй ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлах арга хэмжээ авах боломжтой.

Зөөлөн арга хэмжээ нь ихэвчлэн төрийн байгууллага болон батлан хамгаалах салбарын ханган нийлүүлэгчид өөрсдийн ажилтан, албан хаагчдад зориулсан гаргасан Ёс зүйн дүрмийг мөрдүүлэх хэлбэрээр илэрнэ.

#### Тодруулга 5. Хувь хүний ёс зүйг бэхжүүлэх талаарх Польшийн жишээ

Нийт ахлах офицерууд болон санхүү, ложистикийн албаны бага тушаалын офицерууд хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх үүрэгтэй. Эдгээр мэдүүлгийг олон нийтэд ил болгодоггүй харин Цэргийн цагдаагийн албаны хяналтад байна. Цэргийн албаны сүүлийн гурван жилд худалдан авах ажиллагаанд оролцож байсан албан тушаалтан батлан хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн компанид ажилд орохыг хориглодог байна.

Шүгэл үлээгчдийн хамгаалалт нь хатуу болон зөөлөн арга хэмжээний дунд орших бөгөөд авлигын талаарх мэдээлэл бүхий хүмүүс зохих газарт хандаж, мэдээлэл өгөх явдлыг дэмжихэд чиглэгдэнэ.

## Тодруулга 6. Шүгэл үлээгчдийг хамгаалах тэргүүний туршлагаас

Норвеги Улс шүгэл үлээгчийг хамгаалах тусгай хуультай. Уг хуулийн дагуу төрийн болон хувийн хэвшилд ажилладаг хэн ч болов өөрийн байгууллагад гарсан авлигын талаарх мэдээллийг холбогдох албан тушаалтанд мэдэгдэх эрхтэй бөгөөд ингэхдээ “зохих журам”-ыг баримтлах ёстой байдаг. Мөн хуулиар эдгээр албан хаагчдыг мэдээлэл өгсөнийх нь төлөө аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хатуу хориглодог. Шүгэл үлээгч уг мэдээллийг ил болгосон “сайн-муу” шалтгаан нь хуулийн дагуу арга хэмжээ авахад нөлөөлөхгүй бөгөөд уг мэдээлэл ил болсноор нийтийн эрх ашиг хангагдаж байх нь чухал. Түүнчлэн мэдээллийг ил гаргана гэдгээ “мэдэгдсэн” (холбогдох баримт бичгийг хувилж үлдэх, хууль бус ажиллагааг зогсоохгүй арга хэмжээ авах г.м) ажилтанг мөн адил хамгаалалтад авдаг. Мэдээллийг ил болгосны дараа шүгэл үлээгчийг ялгаварлан гадуурхсан эсвэл өөр бусад хэлбэрээр “хариу авсан” тохиолдолд түүнд олгох нөхөн олговрын хэмжээнд дээд хязгаар тогтоогоогүй байна.

**Румын Улсын** хуулинд “шүгэл үлээгч” гэсэн нэр томъёоны тайлбарыг оруулсан нь Европтоо цөөнд тооцогдох жишээ мөн.

Уг хуулинд “Шүгэл үлээгч” гэж төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хууль зөрчсөн тохиолдлыг илчилсэн хүнийг хэлнэ” гэж заажээ. Гэхдээ энэ тодорхойлолтыг “нийтийн эрх ашгийн үүднээс шүгэл үлээх” буюу хууль тогтоомж, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, үр дүн, ашигт байдал, ил тод байдлын зарчмуудыг зөрчсөн тохиолдлын талаар өөрийн итгэл үнэмшлийн дагуу мэдээлэх гэсэн суурь ойлголтын хүрээнд авч үзэх нь чухал юм.

**АНУ**-д батлан хамгаалахын бүх гэрээт компани албан ёсоор ёс зүйн сургалт, хөтөлбөр, шүгэл үлээгчийг хамгаалах журмтай байх ёстой. Тухайн гэрээтэй холбоотой гарсан үргүй зардал, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулсан үйл ажиллагаа болон хууль зөрчсөн аливаа үйлдлийн талаар мэдээлсэн тухайн аж ахуйн нэгжийн бүх ажилтан, албан хаагч шүгэл үлээгчийн хамгаалалтад хамаарна. Засгийн газарт мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан тухайн ажилтанг ажлаас халах, цалин хөлс, албан тушаал бууруулах, өөр бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглодог. Мөн эдгээр компани нь шүгэл үлээгчийн эрх, хамгаалалтын талаар өөрийн ажиллагсаддаа бичгээр танилцуулсан байх үүрэгтэй. Мэдээллийн талаарх үүнтэй төстэй шаардлагууд холбооны засгийн газрын албан хаагчдад ч хамаарах бөгөөд э-шуудан, интернэт, утас зэрэг харилцаа холбооны ямар ч аргыг ашиглан, хэрэв өөрөө хүсвэл нэрээ нууцлан мэдээлэл өгөх боломжтой.

### 1. Оролцогч байгууллагуудын ёс зүй

Төсөв санхүүгийн хязгаарлалтыг харгалзан үзвэл батлан хамгаалах бодлого ба худалдан авалтын үйлдээ холбоог хууль журмаар нарийн тогтоосон байх ёстой. аль болох цогц, тэнцвэртэй батлан хамгаалах ерөнхий хөтөлбөрийг боловсруулах үүднээс худалдан авалтын хэрэгцээ шаардлагыг ач холбогдлоор нь эрэмблэх нь чухал. Мөн өрсөлдөөний шаардлага, ашигт байдлын дүн шинжилгээ их чухал.

## Худалдан авалтын ажиллагааны гурван үе шат тус бүрт парламентын гишүүд ямар асуулт тавих ёстой вэ?

### 1. Бэлтгэлийн үе шат

- Батлан хамгаалах салбарын шинэчлэлийн чиглэлийг тодорхой харуулсан бодлогын баримт бичиг нийтлэгдсэн эсэх?
- Худалдан авалтын шийдвэр нь эрсдлийн нягт нямбай, ил тод үнэлгээн дээр үндэслэсэн эсэх?
- Ажиллагааны болон техникийн шаардлагыг ажиллагааны бодит хэрэгцээ шаардлагад тулгуурлаж боловсруулсан эсэх?
- Худалдан авалтын төлөвлөгөөний хэмжээ нь бодит эрэлт хэрэгцээтэй нийцэж байгаа эсэх?
- Техникийн шаардлагын үнэлгээ хийхэд тоон болон чанарын ямар хэмжүүр ашигласан?
- Боломжит ханган нийлүүлэгчдэд (дотоодын компаниудыг оруулаад) худалдан авалтын мэдээллийг урьдчилан хүргэсэн эсэх?
- Худалдан авалтын төлөвлөгөөг иж бүрэн систем эсвэл аль нэг хэсгийг нь авахад зориулж хийсэн эсэх?
- Мөнгөн дүн нь төслийн хугацаанд шаардлагатай нийт төсвийн хэмжээ мөн үү?
- Засвар үйлчилгээний зардал багтаж байгаа юу?
- Урьдчилан төлөвлөгөөгүй худалдан авалт нь ажиллагааны бодит яаралтай шаардлагад үндэслэсэн эсэх?

### 2. Сонгон шалгаруулах, яриа хэлцлийн үе шат

- Сонгон шалгаруулалт өрсөлдөөний зарчимд суурилсан эсэх? Үгүй бол, ганц эх үүсвэрээс худалдан авалт хийх (хаалттай сонгон шалгаруулалт хийх) хангалттай үндэслэл бий эсэх?
  - Сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналд үнэлгээ хийх үнэн зөв, объектив шалгуур үзүүлэлтүүд бий эсэх?
  - Ханган нийлүүлэгчдээс ирүүлсэн үнийн саналыг харьцуулахдаа бүтээгдэхүүн/үйлчилгээ үргэлжлэх мөчлөгийн зардал эсвэл зөвхөн анхны үнийн саналыг харгалзсан ?
- Сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичиг нь ойлгомжтой, бодитой эсэх?
- Ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлж байгаа вэ? Уг ажиллагаанд оролцож буй албан тушаалтнууд ханган нийлүүлэгчтэй ашиг сонирхлын зөрчил гэж үзэж болохуйц харилцаа холбоотой эсэх? Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдүүлэг гаргаж өгсөн эсэх? Тийм бол, уг мэдүүлгийг хэрхэн баталгаажуулсан?

Худалдан авалтын явцад “итгэмжлэгдсэн төлөөлөгч”, “зуучлагч” оролцож байгаа эсэх? Тэдний ёс зүйг яаж баталгаажуулсан вэ?

### 3. Хэрэгжилтийн үе шат

- Худалдан авалтын гэрээнд Батлан хамгаалах яамны эрхийг тусгасан эсэх?
- Гэрээ анх батлагдсаны дагуу хэрэгжиж байгаа эсэх?
- Зөвхөн тодорхой, үндэслэл бүхий нөхцөл байдалд Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж байгаа эсэх?
- Чанарыг бодитойгоор шалгах боломж бий эсэх?

## Нөхөн төлбөрийн \офсет\ хэлцэл дэх авлигын эрсдлүүд

Өндөр хөгжилтэй орнуудад ч нөхөн төлбөр авлигын томоохон эрсдэл дагуулдаг. Гадаадын ханган нийлүүлэгчээс бүтээгдэхүүн үйлчилгээ худалдан авсаны төлөө дотоодын холбогдох компаниудад нөхөн төлбөр хийдэг. Батлан хамгаалахын олон улсын гэрээ хэлцэлд ийм зохицуулалт заавал хийгддэг бөгөөд тодорхой хэмжээнээс дээш гарсан үнийн дүн бүхий гэрээнд нөхөн төлбөр хийх заалт заавал оруулахыг зарим орны хуулиар тогтоосон байдаг.

Нөхөн төлбөрийн тохиролцоо нь хамтран үйлдвэрлэх, лицензээр үйлдвэрлэх, маркетинг, экспортын туслалцаа үзүүлэх, туслан гүйцэтгэх, сургалт явуулах, технологи шилжүүлэх, санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх зэрэг олон хэлбэртэй байж болно.

Нөхөн төлбөр нь дотоодын аж үйлдвэрийн хөгжлийг дэмжиж, худалдааны балансыг тэнцвэржүүлэх зэрэг олон ач тустай. Түүнчлэн, батлан хамгаалахын томоохон гэрээ хэлцэлтэй холбоотой асуудлаар дотоодын үйлдвэрлэгч, олон нийтийн эсэргүүцлийг зөөллөх боломжийг засгийн газарт олгодог. Чухам юу хэрэгцээтэй байгаа, тэр ч байтугай үнэхээр хэрэгцээтэй эсэхийг тодорхойлоход нөхөн төлбөрийн тухай заалт чухал нөлөө үзүүлж болно.

Батлан хамгаалахын худалдан авалт нь эдийн засгийн энгийн ажиллагаанаас хавигүй өөр. Ийм гэрээ хэлцэл олон улсын улс төрийн хэмжигдэхүүнтэй бөгөөд худалдан авагч улс нь нийлүүлэгч улс оронтой улс төрийн харилцаагаа гүнзгийрүүлэх эрмэлзэлтэй байгааг илэрхийлдэг. Түүнчлэн, гэрээ хэлцлийн хэмжээ хангалттай том байдаг тул ханган нийлүүлэгчийн зүгээс тухайн улс, муж, хотод санал болгож буй хөрөнгө оруулалт, ажлын байр, бүтээгдэхүүн үйлчилгээ нь худалдан авалтыг дэмжих дотоодын улс төрд ч нөлөө үзүүлдэг. Эл ашиг нь тааруухан бараа ч улстөрийн хувьд сонирхол татахуйц болгож чадна.

### Тодруулга 7. Ойрхи Дорнод ба Ази дахь нөхөн төлбөр

Нөхөн төлбөр нь зөвхөн батлан хамгаалах салбар дахь хөрөнгө оруулалтаар хязгаарлагдахгүй. Саудын Араб- Их Британий батлан хамгаалах гэрээний дагуу британийн компаниуд тус улсын нутаг дэвсгэр дээр элсэн чихэр боловсруулах үйлдвэр, эмийн үйлдвэр, компьютерийн сургалтын төв зэргийг байгуулж байв. Малайзын нөхөн төлбөрийн гэрээ нь тус улсын их дээд сургуульд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар дээд боловсролын салбарыг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болсон бол Кувэйтэд иргэний жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлтэй байжээ.

Түүнчлэн зарим улс орон нөхөн төлбөрт “итгэлцүүр” тогтоож, тэргүүлэх ач холбогдолтой салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ашигладаг байна. Жишээлбэл, хэрэв итгэлцүүрийг 3 гэж тогтоосон бол хөрөнгө оруулалт хийсэн гадны компани өөрийн оруулсан бодит офсет хөрөнгийг 3 хүртэл дахин нэмэгдүүлсэн хэмжээний төлбөр авах боломжтой гэсэн үг. Хэрэв Батлан хамгаалах яаманд танкны хуяг үйлдвэрлэх тусгай технологи яаралтай шаардлагатай болж, итгэлцүүрийг 4 хэмээн тогтоосон бол 20 сая ам.долларын үнэ бүхий технологийг санал болгосон ханган нийлүүлэгч 80 сая ам.долларын нөхөн төлбөр авах эрхтэй болно гэсэн үг. Гэхдээ нөгөө талаас ийм нөхцлийг ашиглан ханган нийлүүлэгчид тухайн улс дахь офсет хөрөнгө оруулалтын бодит хэмжээг бууруулах оролдлого гарах нь бий. Жишээ нь, АНУ-ын батлан хамгаалахын нэгэн томоохон ханган нийлүүлэгч Персийн булангийн нэг улсад 10 тэрбум ам.долларын

нэрлэсэн дүн бүхий үүрэг хүлээсэн байсан ч итгэлцүүрийн нөхцлийг ашиглан зөвхөн 1 тэрбум ам.доллараар гүйцэтгэлээ биелүүлсэн байна. Мөн Шведийн нэр бүхий ханган нийлүүлэгч зөвхөн 3 сая ам.доллараар Өмнөд Африкийн Порт Элизабет хотын усан сангуудыг шинэчлэн засварлаж, Шведийн жуулчдыг татах маркетинг явуулсныхаа төлөө 200 сая ам.долларын нөхөн төлбөр авчээ.

Олон оронд итгэлцүүрийг урвуулан ашиглах, итгэлцүүрийн дагуу хүлээсэн үүргийг гуйвуулахаас сэргийлэх үүднээс итгэлцүүрийн үнэнд хязгаар тогтоох буюу тодорхой нөхцөл дагалдуулдаг. Тухайлбал, Энэтхэгт итгэлцүүрийн дээд хэмжээ 3 бөгөөд гадны компани шаардлагатай технологийг үйлдвэрлэлт, борлуулалт, экспортын тоо хэмжээнд аливаа хязгаарлалт тавилгүйгээр нийлүүлсэн тохилдолд л ашиглагддаг байна.

Улс	Офсет гэрээний доод үнийн дүн	Офсетын доод хувь	Итгэлцүүр
Австри	726,000 евро	100%	10х хүртэл
Бельги	11 сая евро	100%	Заагаагүй
Болгар	5 сая евро	110%	1- 3х
Чех	500 сая коруна	100%	Байхгүй
Дани	25 сая крон	100%	Заагаагүй
Грек	10 сая евро	80-120%	1-10х
Унгар	3.5 сая евро	100%	15х хүртэл
Литва	1.5 сая евро	100%	1-5х
Нидерланд	5 сая евро	100%	1-5х
Норвеги	5.5 сая евро	100%	1-5х
Польш	5 сая евро	100%	2-5х
Румын	3 сая евро	80%	5х хүртэл
Словен	500,000 евро	100%	1-7х
Швед	10 сая евро	100%	-
Швейцарь	15 сая франк	100%	2- 3х

20 сая ам.долларын үнэ бүхий технологийг санал болгосон ханган нийлүүлэгч 80 сая ам.долларын нөхөн төлбөр авах эрхтэй болно гэсэн үг. Гэхдээ нөгөө талаас ийм нөхцлийг ашиглан ханган нийлүүлэгчид тухайн улс дахь офсет хөрөнгө оруулалтын бодит хэмжээг бууруулах оролдлого гарах нь бий. Жишээ нь, АНУ-ын батлан хамгаалахын нэгэн томоохон ханган нийлүүлэгч Персийн булангийн нэг улсад 10 тэрбум ам.долларын нэрлэсэн дүн бүхий үүрэг хүлээсэн байсан ч итгэлцүүрийн нөхцлийг ашиглан зөвхөн 1 тэрбум ам.доллараар гүйцэтгэлээ биелүүлсэн байна. Мөн Шведийн нэр бүхий ханган нийлүүлэгч зөвхөн 3 сая ам.доллараар Өмнөд Африкийн Порт Элизабет хотын усан сангуудыг шинэчлэн засварлаж, Шведийн жуулчдыг татах маркетинг явуулсныхаа төлөө 200 сая ам.долларын нөхөн төлбөр авчээ.

Олон оронд итгэлцүүрийг урвуулан ашиглах, итгэлцүүрийн дагуу хүлээсэн үүргийг гуйвуулахаас сэргийлэх үүднээс итгэлцүүрийн үнэнд хязгаар тогтоох буюу тодорхой нөхцөл дагалдуулдаг. Тухайлбал, Энэтхэгт итгэлцүүрийн дээд хэмжээ 3 бөгөөд гадны компани шаардлагатай технологийг үйлдвэрлэлт, борлуулалт, экспортын тоо хэмжээнд аливаа хязгаарлалт тавилгүйгээр нийлүүлсэн тохилдолд л ашиглагддаг байна.

## Офсетийн талаар парламентын гишүүд ямар асуулт тавьж болох вэ ?

- Офсет гэрээний зорилгыг тодорхойлсон үндэсний стратеги бий эсэх?
- Офсет гэрээ байгуулахад засгийн газрын харьяа аль агентлагууд оролцдог вэ?
- Офсетийн хэлцлийг худалдан авалтын гэрээ байгуулсны дараа эсвэл өмнө хийж байгаа эсэх?
- Офсет гэрээнд цаг хугацааны хязгаар, биелэлтийн стандарт бий эсэх, гэрээний үүргээ биелүүлээгүй бол хүлээлгэх хариуцлагыг заасан эсэх? Итгэлцүүр нь үндэсний батлан хамгаалах, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй нийцэж байгаа эсэх?
- Офсетийн бодлого хэнд ашигтай вэ: тодорхой салбарт, компанид, эсвэл хувь хүмүүст үү?
- Нэг буюу хэсэг салбарын итгэлцүүр бусдаасаа хэт өндөр байгаа эсэх? Энэ нь ханган нийлүүлэгчид офсетэд зарцуулах бодит хөрөнгө оруулалтыг бууруулах боломж олгох эсэх?
- Ханган нийлүүлэгчэд зориулсан аудитын, санхүүгийн эрх зүйн шалгалт бий эсэх?
- Батлан хамгаалах яам болон ханган нийлүүлэгчдэд офсетийн гэрээтэй холбоотой ёс зүйн дүрэм бий эсэх? Технологи, зэвсэг техник нийлүүлэлтийн аль шатанд гадаадын ханган нийлүүлэгч офсет кредит нэхэмжлэх боломжтой вэ?
- Батлан хамгаалах яамны зүгээс ханган нийлүүлэгчдэд тайлан тэнцэлдээ гүйцэтгэлийн бонд тусгаж оруулах шаардлага тавьсан уу? (Ийм бонд цаг хугацаа өнгөрөх тусам гэрээний гүйцэтгэлийн хэмжээгээр суутгагдан хасагдах бөгөөд ил тод байдлыг бэхжүүлж, авлигаас урьдчилан сэргийлэхэд тустай байдаг.)

## Зэвсэг техникийн зориулалтыг хөрвүүлэх явц дахь авлигын эрсдлүүд

Батлан хамгаалах салбар дахь парламентын болон олон нийтийн хяналт ихэвчлэн өндөр үнэтэй зэвсгийн шинэ систем худалдан авах, бүтээн байгуулалтын шинэ төсөлд ихэвчлэн төвлөрдөг. Гэтэл илүүдэл зэвсгийн систем, зэвсэг техник, дэд бүтцийг худалдах зэрэг анхааралд бага өртөх худалдан авалтын ажиллагааны ард ч авлига байх боломжтой. Зэвсэг техникийн зориулалтыг хөрвүүлэх хөтөлбөрийн зарим чиглэл ёс зүйн асуудалд хүргэх эрсдэлтэй. Үүнд, цэргийн бааз, байгууламжийн зориулалтыг өөрчилж шинэчлэх, илүүдэл зэвсэг техникийн устгал, цэргийн аж үйлдвэрийн бүтцийг шинэчлэн зохион байгуулах зэргийг дурдаж болно.

Олон оронд зэвсэгт хүчний мэдэлд ихээхэн хэмжээний өмч, дэд бүтэц, аж үйлдвэрийн байгууламж, илүүдэл зэвсэг техник байх бөгөөд арилжааны үүднээс эдгээр нь ихээхэн сонирхол татдаг. Жишээ нь, хувийн хэвшлийн зүгээс өндөр үнэ цэнэ бүхий өмчийг цаашид батлан хамгаалах салбарт шаардлагагүй гэсэн дүгнэлт гаргуулах эсвэл худалдан авах, солихын өмнө зах зээлийнхээс доогуур үнэ тогтоолгохоор оролдох магадлал өндөр. Өмч хөрөнгийн ийм бартер солилцоо нь худалдан авалтаас ч илүү авлигын эрсдлийг дагуулж байдаг.

Нөгөө талаас, ажлын байр, ашиг орлогоо алдахад хүргэж болзошгүй гэх үндэслэлээр цэргийн баазыг хаах, өмч хөрөнгө шилжүүлэхийн эсрэг олон нийтийн дарамт шахалт болон муж, орон нутаг, бизнесийн тодорхой бүлэглэлийн лобби (хууль ёсны болон хууль бус) батлан хамгаалах яаманд ихээр ирдэг. Ингэхдээ эдгээр өмч хөрөнгө, үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангахад цаашид огт хэрэгцээгүй, батлан хамгаалах төсөв хөрөнгө дэмий үрж байгаа нь огт хамаагүй байдаг.

Агуулахын харуул хамгаалалт, илүүдэл сум, зэвсэг техникийн устгал зэрэг тодорхой үйлчилгээг гаднаас авах нь гэрээ, сонгон шалгаруулалтад нөлөөлөх оролдлого, эсбөгөөс өрсөлдөгчгүй ганц компанитай гэрээ байгуулах оролдлогод хүргэх болзошгүй. Аль аль тал нь гэрээний хэрэгжилтийг аль болох сунжруулах, ингэснээр илүүдлийн устгалыг хойшлуулах сонирхолтой байж болно. Гэхдээ батлан хамгаалахын бусад гэрээ хэлцлийн нэгэн адил ийм сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж, өрсөлдөөний зарчимд суурилан, тодорхой шалгуурын дагуу ил тод явуулсан тохиолдолд авлигын эрсдэл даган буурдаг.

## Зэвсэг техникийн зориулалтыг хөрвүүлэхтэй холбогдуулан парламентын гишүүд ямар асуулт тавьж болох вэ?

- Зэвсэг техникийн зориулалтыг өөрчлөх, аутсорсинг, хувьчлалын албан ёсны урт хугацааны төлөвлөгөө, стратеги Батлан хамгаалах яаманд бий эсэх?
- Энэ нь батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарын өнөөгийн болон ирээдүйн ажиллаганы хэрэгцээ шаардлагад хэрхэн нөлөөлөх вэ?
- Энэхүү ажиллагаанд оролцож буй төрийн болон хувийн хэвшлийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой тодорхой дүрэм журам бий эсэх?
- Худалдан авалтын ажиллагаанд оролцож буй компани, хувь хүмүүст зориулсан ёс зүйн дүрэм бий эсэх?
- Гэрээ хэлцэл байгуулахад оролцсон албан тушаалтнуудыг урьдчилсан шалгасан эсэх? Эдгээр албан тушаалтнууд тодорхой хугацааны давтамжтайгаар хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлэг бөглөж, нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэг эсэх?
- Ажиллагаанд оролцогчдын зүгээс авлига, сэжигтэй үйлдлийн талаар, шүгэл үлээгчийг хамгаалах журмын дагуу зохих газарт мэдээлэх механизм бий эсэх?

Зарим оронд батлан хамгаалах салбар нь өөрөө эдийн засгийн тоглогч байж, нөөц (хүн хүч, өмч хөрөнгө)-өө ашиглан ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах замаар цэргийн зардалд зориулах санхүүжилтийг төсвөөс гадуур төвлөрүүлдэг. Ийм үйл ажиллагаатай холбогдох эрсдэл хоёр талтай. Нэгдүгээрт, зэвсэгт хүчний хүн хүч, нөөц бололцоог хувийн хэвшил рүү чиглүүлбэл мэргэжлийн төвшинд сөргөөр нөлөөлөх магадлалтай. Улмаар зэвсэгт хүчин төр, иргэдийн аюулгүй байдлыг хангах бус харин ашиг олох сонирхол нь давамгайлж болзошгүй. Хоёрдугаарт, зэвсэгт хүчний хариуцлагатай байдлыг сулруулах эрсдэлтэй. Өөрийгөө санхүүжүүлэх бие даасан эх үүсвэртэй болсон арми иргэний хяналтаас алдуурч, нийгэмд гүйцэтгэх ерөнхий чиг үүрэг нь ч эрсдэлд орж болзошгүй.



## Зэвсэг техникийн зориулалтыг хөрвүүлэх явц дахь авлигын эрсдлүүд

**Парламент** авлигыг бууруулахад голлох үүрэгтэй оролцоно. Ингэхдээ юуны өмнө батлан хамгаалах, аюулгүй байдлын үйл ажиллагааны хууль зүйн баттай сүүрийг бий болгох ёстой. Хууль тогтоомж нь нарийн тодорхой байж, ил тод, хариуцлагатай байдлыг шаардаж, хууль бус үйлдлийг нарийвчлан тодорхойлсон байх ёстой. Түүнчлэн, жил тутмын батлан хамгаалах төсвийн хэлэлцүүлэг, асуулт, асуулгын хороод, төсөв болон батлан хамгаалах асуудал хариуцсан хороодоороо дамжуулан батлан хамгаалах төсөв, худалдан авалтад ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэхэд парламент анхаарах ёстой.

### Тодруулга 8. Парламентын хяналтын тэргүүний туршлага

**Нидерланд:** 25 сая еврогоос дээш үнийн дүн бүхий худалдан авалтын бүх шийдвэр парламентаар дамжих ёстой. Парламент нь худалдан авалтын эцсийн шийдвэрийг эсэргүүцэх, өөрчлөх эрхтэй төдийгүй худалдан авах ажиллагааны бүхий л үе шатанд гарах шийдвэрт нөлөөлөх боломжтой байдаг. 100 сая еврогоос дээш үнийн дүн бүхий төслийн явцыг парламентад илүү дэлгэрэнгүй, илүү ойр давтамжтайгаар тайлагнана.

**Болгар:** 2009 онд тус улсын батлан хамгаалахын сайд зэвсэг техникийн худалдан авалтад сайдын эдлэх эрх мэдлийг хязгаарлах тухай нэмэлт өөрчлөлтийг Батлан хамгаалах, зэвсэгт хүчний тухай хуульд оруулах санаачилга гаргасан. Энэ нэмэлт өөрчлөлтийн дагуу 25 сая евро хүртэлх үнийн дүнтэй худалдан авалтыг сайд бие даан шийдэх бөгөөд харин 25-50 сая еврогийн дүн бүхий худалдан авалтыг засгийн газраар, 50 сая еврогоос дээш үнийн дүнтэй худалдан авалтыг парламентаар зөвшөөрүүлж байх аж.

**Герман ба Польш:** Германд 25 сая евро, Польшид 28 сая еврогоос дээш үнийн дүн бүхий батлан хамгаалахын гэрээг парламентын батлан хамгаалах асуудал эрхэлсэн хороо баталдаг байна.

Батлан хамгаалах төсвийн хяналтыг батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн парламентын байнгын хороо ихэвчлэн хэрэгжүүлдэг. Хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэх эрх мэдэл, чадавх, хүсэл зоригтой байх ёстой:

- Жил бүрийн батлан хамгаалах төсвийн зүйлүүдийг нэг бүрчлэн хянах
- Сайд, дээд удирдлага болон цэргийн албан тушаалтнуудын илтгэлийг сонсох, асуулга явуулах
- Гүйцэтгэх засгийн байгууллагуудаас хэрэгцээтэй баримт бичиг, тайланг шаардаж гаргуулах
- Төсвийн зарцуулалтын тайланг хянан үзэж, эрх бүхий байгууллагаар аудит хийлгэх хүсэлт гаргах
- Цэргийн бие бүрэлдэхүүн, иргэдээс ирүүлсэн гомдол, хүсэлтийг хянаж үзэх
- Дотоодын болон хилийн чанад дахь цэргийн бааз, анги байгууллагатай танилцах.

Хянан шалгах арга хэрэгсэл хэдий чухал ч авлигатай тэмцэх хамгийн шилдэг арга зам бол мэргэжил мэдлэг, итгэл үнэмшил, дүн шинжилгээ хийх чадвартай ажилтнуудаар дамжин хэрэгждэг ойлгомжтой, ил тод дүрэм журам юм. Хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм

судлаачидтай холбоотой ажиллах нь нэмэлт мэдээлэл, бодлогын эх үүсвэрээр хангадаг тул улам бүр ач холбогдолтой болж байна.

Батлан хамгаалах салбар дахь авлигын эсрэг тэмцлийг **Батлан хамгаалах яам** манлайлж оролцох нь зүйн хэрэг. Энэ үүргээ биелүүлэхийн тулд тус яаманд урьдчилан сэргийлэх, хууль журмын хэрэгжилтийг хангах, алдаа дутагдлыг засч залруулах захиргааны хариуцлагын арга хэмжээ авах эрх бүхий дотоод хяналтын оновчтой тогтолцоо байх ёстой.

Үүнээс гадна, Батлан хамгаалах яам дараах дүрэм журам, тогтолцоог зайлшгүй нэвтрүүлсэн байна. Үүнд:

- Батлан хамгаалах зорилтууд буюу зэвсэгт хүчний байр суурь, чиг үүрэг ил тод, ойлгомжтой байх
- Батлан хамгаалах дунд хугацааны (5 жил) бодлогоор тодорхойлсон үйл ажиллагаатай уялдуулан салбарын төсөв хөрөнгийг хуваарлалтын төлөвлөгөө, шийдвэрүүд
- Албан тушаал дэвшүүлэх бүх шийдвэр, шилжилт хөдөлгөөн, чухал үүрэг даалгаварыг хянан үздэг цэргийн болон иргэний дээд албан тушаалтнуудаас бүрдсэн хяналтын хороо бүхий хүний нөөцийн удирдлагын төвлөрсөн тогтолцоо
- Худалдан авалт, засвар үйлчилгээний гэрээг нарийвчлан хянадаг байх
- Батлан хамгаалах яаманд батлан хамгаалахын болон төрийн удирдлагаар мэргэшсэн энгийн боловсон хүчин ажиллах
- Ашиг сонирхлын зөрчлийг олж тогтоох, урьдчилан сэргийлэх тогтолцоо
- Орлогынхоо тодорхой хувийг дарамт шахалтын дор удирдлагадаа хураалгадаг авлигын сүлжээнд орохоос бага, дунд төвшний албан хаагчдыг хамгаалах арга хэмжээ

Гүйцэтгэх засгийн гол зорилго нь авлигыг хувийн хэрэгцээ шаардлага болон байгууллагын соёлоос үүдэлтэй энгийн үзэгдэл хэмээн эвлэрдэггүй ажлын орчинг бий болгоход оршино. Батлан хамгаалах бие бүрэлдэхүүний чадавх, мэргэжлийн ёс суртахууныг сайжруулах нь салбарын албан хаагчид үүрэгт ажлаа үр дүнтэйгээр, авлигаас ангид гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

### Тодруулга 9. Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий тусгай бүтцүүд

**Сьерра Леоны** Авлигатай тэмцэх хороо нь худалдан авалтын ажиллагаан дахь авлигатай тэмцэх, шүгэл үлээгчдийг хамгаалах шийдмэг алхмуудыг авч хэрэгжүүлсэн. Төрийн албан хаагч ёс зүйн дүрэм зөрчсөн ямар ч тохиолдолд сахилгын шийтгэл оноодог. Авлигын эсрэг шинэ хуулиар авлигатай холбоотой гэмт хэргийн төрлийг 9-өөс 22 болгож нэмэгдүүлсэн. Авлигын гэмт хэрэгт холбогдогсдод ял завших боломж олгохгүйн тулд шийтгэлийн доод хэмжээг мөн хуульд заажээ. Энгийн 12 иргэнийг хахуульдах буюу нөлөөлөх нь ганц шүүгчид нөлөөлөхөөс хялбар гэдгийг судалгаагаар тогтоосон тул шүүх хурлыг иргэний төлөөлөл бус шүүгч даргалан явуулах болсон. Шүгэл үлээгчдийг хуулиар хамгаалан, үнэ төлбөргүй шууд дугаар ажиллуулж, хэрэгтэй холбоотой мэдээлэл, шүүн таслах ажиллагааны амжилтаас хамааран авлигын дүнгийн 10 хүртэлх хувийг тэдэнд урамшуулал болгон олгодог байна.

Омбудсмэний байгууллагыг авлигатай тэмцэхэд гол үүрэгтэй гэж үздэггүй. Гэхдээ оновчтой зохион байгуулж, улс төрийн зохих дэмжлэг үзүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангасан тохиолдолд тэдгээр байгууллага нь авлигаас урьчилан сэргийлэх, таслан зогсоох үндэсний стратегийн хэрэгжилтэд чухал үүрэг гүйцэтгэж чадна.

Омбудсмэний байгууллагын мэдэлд хянан шалгах ажиллагаа, тайлан, олон нийтэд хандсан мэдэгдэл, парламентад зориулсан мэдээлэл, засгийн газрын удирдах албан тушаалтнуудтай уулзалт хийх зэрэг батлан хамгаалах салбарын ёс зүйг бэхжүүлэхэд ашиглаж болох олон арга хэрэгсэл бий. Омбудсмэний байгууллагын гүйцэтгэх үүрэг дараах ач холбогдолтой. Үүнд:

- Батлан хамгаалах салбарын ямар ч албан хаагч зэвсэгт хүчинтэй холбоотой шийдвэр, чиг үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар омбудсмэний байгууллагад хандах нь нээлттэй байхын зэрэгцээ энгийн иргэн ч батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудлаар тус байгууллагад хандах эрхтэй байх ёстой
- Омбудсмэний байгууллага командын босоо тогтолцооноос хамааралгүй байдаг тул авлигын хэрэг гарсан гэж үзсэн тохиолдолд ашиглах харилцаа холбооны нэмэлт сувгийн үүрэг гүйцэтгэх боломжтой
- Омбудсмэний байгууллага нээлттэй, идэвхтэй байснаар шүүх прокурор, захиргааны болон цэргийн сахилгын шийтгэлээс гадуур үлдсэн жижиг хэмжээний авлигатай тэмцэх боломжийг бүрдүүлдэг
- Батлан хамгаалах салбарын бүх шийдвэрт тогтмол, хүссэн үедээ шалгалт хийх эрхтэй байдаг нь тус салбарт дотоод болон хөндлөнгийн хяналтыг бүх үе шатанд тавьж байгааг сануулах байнгын сануулга болдог
- Омбудсмэний байгууллага нүүц баримт бичиг, барилга байгууламжтай танилцах өргөн хүрээтэй эрх эдэлдэг тул авлигыг хаацайлсан баримт бичиг, нотлох баримт, үйл ажиллагааг хуурамчаар үйлдэх боломжийг хязгаарладаг
- Омбудсмэн ажлын үр дүнгээ нээлттэй мэдээлж, авлигад холбогдсон улс төрчид, цэргийн болон энгийн албан тушаалтнуудын нэрсийг зарлах чадавхтай байдаг нь тэдгээр албан тушаалтан өөрийн ажил алба, нэр төрөө сэвтүүлэхгүй байхыг эрмэлзэх томоохон хүчин зүйл болдог

**Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагууд** авлигатай тэмцэхэд нэн чухал үүрэгтэй байдаг. Тэд засгийн газар, парламент, олон нийттэй дараах таван үндсэн хэлбэрээр хамтран ажиллах боломжтой. Үүнд:

- Авлигын бодит төлөөсийн талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлж, ёс зүйг бэхжүүлэх санал санаачилгад шаардлагатай дэмжлэгийг нийгэмд бий болгох
- Өөрчлөлт шинэчлэл, олон нийтийн хэлэлцүүлгийг эхлүүлэгч, зүүчлагчийн үүрэг гүйцэтгэх
- Мэргэжлийн мэдлэг, туршлагаар хангах
- Судалгаа хийж, бодлогын хувилбар боловсруулах
- Мониторинг хийж, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих

Ёс зүйг бий болгож төлөвшүүлэхэд хэвлэлийн гүйцэтгэх гол үүрэг бол зүй бус үйлдлийг илчилж мэдээлэхэд оршино. Хараат бус хэвлэл сайн засаглалын үндсэн хэрэгсэл бөгөөд нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар үнэн зөв, тэнцвэртэй, шуурхай мэдээлэл хүргэснээр иргэд цаг үеийн асуудлаар мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжтой байна.

## **Тодруулга 10. Төсвийн шинжилгээний талаарх иргэний нийгмийн туршлага**

Латин Америкийн төрийн бус байгууллага RESDAL нь нийт 300 гаруй судлаач мэргэжилтнүүдээс бүрддэг бөгөөд 2001 оноос хойш аюулгүй байдлын төсвийн чиглэлээр мэргэшин ажиллаж байгаа. Тус байгууллага батлан хамгаалах төсвийн шийдвэр гаргах үйл явцад дүн шинжилгээ хийх аргачлалыг боловсруулсан. Үүнд батлан хамгаалах бодлогын цар хүрээ, дотоодын хууль тогтоомжийн чиг хандлага, гүйцэтгэх болон хууль тогтоох засгийн чиг үүрэг, дотоод болон хөндлөнгийн хяналт, иргэний нийгмийн үйл ажиллагааг нэгтгэн авч үздэг аж. Энэ аргачлалыг Аргентин, Болив, Бразил, Чили, Колумб, Эквадор, Гуатамала, Хондурас, Мексик, Никарагуа, Парагвай, Перу, Венесуэль зэрэг орны батлан хамгаалах төсөвт дүн шинжилгээ хийхэд ашиглаад байна. *Латин Америкийн орнуудын батлан хамгаалах салбарын харьцуулсан атлас*-т Латин Америкийн арван зургаан орны батлан хамгаалах төсөвт хийсэн дүн шинжилгээний үр дүнг тусгадаг. Энэ нь бүс нутгийн ийм мэдээллийн анхны эх үүсвэр бөгөөд харьцуулах аргачлалаар гаргасан үзүүлэлтүүдийг харуулдаг байна. Уг атластай дараах холбоосоор орж танилцах боломжтой. <http://www.resdal.org/>

Эцэст нь тэмдэглэхэд, авлигатай тэмцэхэд улс төр, нийгэм, эдийн засгийн шинэчлэл, харилцан адилгүй олон байгууллагыг хамарсан олон талт стратеги хэрэглэх нь ганц чиглэлээр авч буй арга хэмжээнээс илүү үр дүнтэй байх нь мэдээж.

## **Батлан хамгаалах салбарт ёс зүйг бэхжүүлэх олон улсын ямар хэм хэмжээ, туршлага байдаг вэ?**

Европын холбооны хэмжээнд **Европын батлан хамгаалах агентлагаас** эрхлэн гаргадаг **Европын батлан хамгаалах гэрээ хэлцлийн боломжуудын талаарх** товхимлыг ашиглах замаар нээлттэй сонгон шалгаруулалтыг дэмжих санал санаачилгууд бий. Ингэснээр засгийн газар хоорондын хамтын ажиллагааг сайжруулж, батлан хамгаалахын худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаад зогсохгүй, гишүүн орнуудын хооронд хэм хэмжээ, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн нарийвчилсан код, дүрэм журмыг хэрэглэдэг байна.

**Ёс зүйг бэхжүүлэх НАТО-ын санаачилга** нь анх НАТО болон Транспаренси Интернэшнл хоорондын яриа хэлцлийн дүнд бий болсон бөгөөд авлигын эрсдлийг бууруулах олон улсын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх зорилготой. Уг санаачилга нь Евро-Атлант, Газар дундын тэнгисийн бүс нутаг, Персийн булан болон дэлхийн өнцөг булан бүрт орших НАТО-ын холбоотон, түншүүд (Афганистаныг оролцуулаад)-д нээлттэй. Оролцоо нь цэвэр сайн дурын үндсэн дээр хэрэгжих ба хэрэгжилтэд тухайн улс өөрөө хариуцлага хүлээж, хүчин чармайлт, идэвх санаачилга гаргах суурь нөхцөлтэй. Үйл ажиллагааны гол чиглэл нь НҮБ, Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага болон олон улсын бусад гэрээ хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь улс орнуудад тус болох практик мэдлэгийг бий болгох явдал бөгөөд үүнд өөрийн ёс зүйн үнэлгээний арга хэрэгслүүд, сургалтын тусгай хөтөлбөр, дугуй ширээний ярилцлага, хэвлэмэл ном, гарын авлага, сайн туршлага,

судалгаа шинжилгээ зэрэг багтана. Уг санаачилгад парламентын гишүүд, албан хаагчид, иргэний нийгмийн оролцох боломжтой.

### **Батлан хамгаалах салбарт ёс зүйг бэхжүүлэхийн тулд парламентын гишүүн юу хийх боломжтой вэ?**

- Батлан хамгаалах салбарын ёс зүйг улс төрийн хэлэлцүүлэг, хууль тогтоох үйл ажиллагааны нэгэн чухал сэдэв болгох
- Авлига, ёс зүйн асуудлаар үнэн зөв дүгнэлт мэдээллийг аль болох олон эх үүсвэрээс гаргуулж авах. Үүнд, яамд, аудитын газар, хараат бус судлаачид г.м
- Батлан хамгаалах салбарт ёс зүйг бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулах
- Бизнесийн үйл ажиллагаанд оролцож буй төрийн албан тушаалтан, хувийн хэвшлийн албан хаагчдад зориулсан ёс зүйн хэм хэмжээг тодорхой тогтоож, хүний нөөцийн сургалт, ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хянах тогтолцоог нэвтрүүлэх хүсэлт гаргах
- Авлигын хэрэгт үр нөлөөтэй, зохистой, баттай шийтгэл оноох үүднээс хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах
- Худалдан авалтын ажиллагааг хянахад үндэсний аудитын газар, иргэний нийгмийн байгууллага зэрэг хараат бус байгууллагуудтай хамтарч ажиллах

**Зүүн өмнөд Европын Батлан хамгаалахын сайд нарын процесс (SEDM)** нь Болгар Улсад өргөн хүрээтэй өрнөсөн шинэчлэлийн үйл ажиллагааны үргэлжлэл хэлбэрээр тус улсын манлайлал дор ёс зүйг бэхжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Уг үйл явцын хүрээнд Ёс зүйг бэхжүүлэх хөтөлбөрт Албани, Армен, Босни Герцеговин, Болгар, Хорват, Гүрж, Македон, Монтенегро, Серб, Украин зэрэг орнууд хамрагджээ. 2014 оны байдлаар Босни Герцеговин, Болгар, Хорват, Украин гэсэн орнууд Ёс зүйг бэхжүүлэх өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээг эцэслэн хийгээд байна.

**Европын Зөвлөлийн Авлигын эсрэг эрүүгийн хуулийн конвенцод** дотоод, гадаадын төрийн албан тушаалтан, албан хаагчид, парламентчид, парламентын ассамблейн гишүүд, шүүгч, олон улсын шүүхийн шүүгч, арбитрч, албан хаагчдын идэвхтэй, идэвхгүй хэлбэрийн хээл хахуулийн хэргийг бүхэлд нь хамруулсан байдаг.

### **Батлан хамгаалах салбарын ёс зүйн хэм хэмжээ, туршлагын талаарх эх сурвалжууд**

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн батлан хамгаалах төсвийн ил тод байдлын хэм хэмжээ, зарлагын үр нөлөө, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх арга хэрэгслийн талаарх мэдээллийг олон эх сурвалжаас авч болно.

Батлан хамгаалах салбарт ёс зүйг бэхжүүлж, авлигыг бууруулах нь: Тэргүүний туршлагын эмхэтгэл нь батлан хамгаалах салбар дахь авлигын эрсдэлтэй холбоотой ойлголт, бодлого, стратегийн хувилбарууд, эрсдэл болон эмзэг байдлын талаар дэлгэрэнгүй танилцуулж, авлигатай тэмцэх, ил тод байдлыг бэхжүүлэхэд дотоодын байгууллагуудын

гүйцэтгэх үүргийн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн цогц танилцуулга юм. Уг танилцуулгыг 2010 онд ЗХАХТЖТ-өөс (DCAF) эрхлэн гаргасан бөгөөд 12 хэл дээр орчуулагдсан. <http://dcaf.ch/Publicatons/Building-Integrity-and-Reducing-Corrupton-in-Defence>

**Батлан хамгаалахын компаниудын авлигын эсрэг индексийг** анх 2012 оны 10 дугаар сард Транспаренси Интернэшнлээс гаргасан бөгөөд дэлхийн батлан хамгаалахын хамгийн том 129 компанийн авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан хийгээд аваагүй арга хэмжээний талаарх тайлан юм. <http://companies.defenceindex.org/>

**Батлан хамгаалах салбар дахь авлигын эсрэг Засгийн газрын үйл ажиллагааны индексийг** анх Их Британи дахь Транспаренси Интернэшнлийн салбар 2013 онд гаргасан бөгөөд дэлхийн улс орнуудын батлан хамгаалах салбар дахь авлигын эрсдлийн анхны дүн шинжилгээ юм. Авлигын эрсдлийг бууруулах чиглэлээр дэлхийн 82 улсад авч хэрэгжүүлсэн арга хэмжээг судалж үзсэний дүнд дэлгэрэнгүй тохиол судлал ашиглан батлан хамгаалах салбар дахь парламентын хяналтыг хэрхэн сайжруулж болох арга замуудыг агуулсан байдаг. <http://government.defenceindex.org/>

**ОУВС-аас гаргасан Санхүүгийн ил тод байдлын дүрэм** нь улс орнуудын засгийн газар өөрийн бүтэц, зохион байгуулалт хийгээд төсөв санхүүг ойлгомжтой, тодорхой тайлбарлаж үзүүлэхтэй холбогдсон зарчим, сайн туршлагуудыг агуулдаг. Харин **ОУВС-ийн Санхүүгийн ил тод байдлын гарын авлагад** уг дүрмийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн санал зөвлөмжийг оруулсан бөгөөд сайн туршлагуудыг дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. <http://www.imf.org/external/np/fad/trans/code.htm>  
<http://www.imf.org/external/np/fad/trans/manual.htm>

**Өөрийн ёс зүйн үнэлгээний процесс** нь НАТО-ын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд улс орнууд хоёр шатлалт арга ашиглан батлан хамгаалах ёс зүйн тогтолцоондоо үнэлгээ хийдэг. Үүнд, тухайн улс өөрөө асуулгын хуудас бөглөж ирүүлэх ба дараа нь уг асуулгын дагуу НАТО-ын удирдлага дор мэргэжлийн баг газар дээр нь ирж нөхцөл байдалтай танилцан, асуулга дахь хариултаудын талаар тухайн улсын төлөөлөлтэй үулзаж, санал солилцдог байна. [http://www.nato.int/nato\\_stac/assets/pdf/pdf\\_publications/1402\\_BI-Self-Assess-Quest\\_en.pdf](http://www.nato.int/nato_stac/assets/pdf/pdf_publications/1402_BI-Self-Assess-Quest_en.pdf)

**Цэргийн тэнцвэр (Military Balance)** тайланг Лондон дахь Олон улсын стратегийн судалгааны хүрээлэнгээс (IISS) жил тутам хэвлэн гаргадаг бөгөөд дэлхийн 170 орны цэргийн хүчин чадал, батлан хамгаалах төсөв санхүүгийн үнэлгээг агуулдаг. Уг судалгаанд батлан хамгаалах төсөв, худалдан авалтын нийт мөнгөн дүн, зэвсэг техникийн нөөц, хилийн чанад дахь ажиллагааны талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг ашигласан байдаг. <http://www.iiss.org/en/publicatons/military-s-balance>

**Батлан хамгаалах институцийг бий болгож, бэхжүүлэх НАТО-ын түншлэл** нь тус байгууллагын холбоотон хийгээд түнш орнуудын батлан хамгаалах салбарт санхүү, төлөвлөлт, хуваарилалтын үр нөлөөтэй, ил тод үйл ажиллагааг нэвтрүүлэхийн сацуу, макро эдийн засгийн нөөц боломж, тогтвортой байдлын хүчин зүйлсийг харгалзан үзсэний дүнд батлан хамгаалах зарлагыг үр нөлөөтэй, ил тод, эдийн засгийн хувьд өгөөжтэй байлгах зорилготой. <http://www.nato.int/docu/basictxt/b040607e.htm>

**Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллагаас (OECD) гаргасан Төсвийн ил тод байдлын туршлагауд** нь гишүүн орнуудын туршлагыг дараах сэдвийн дагуу эмхэтгэсэн цуглуулга юм. Үүнд, Төсвийн тайлан; Тусгай мэдүүлгүүд; Ёс зүй, хяналт ба хариуцлагатай байдал.  
<http://www.oecd.org/dataoecd/13/13/33657560.pdf>

**ЕАБХАБ-аас эрхлэн гаргасан Аюулгүй байдлын улс төр-цэргийн талын ёс зүйн дүрэм** нь анх 1994 онд батлагдсан бөгөөд батлан хамгаалах салбарын зарлага нь эдийн засгийн ерөнхий хөгжилд зарцуулагдах ёстой нөөц бололцоог шавхах ёсгүй гэж зөвлөдөг. Түүнчлэн, уг дүрэмд батлан хамгаалах зарлагыг парламентаар батлах ёстой хэмээгээд зэвсэгт хүчний талаарх мэдээлэл нь ил тод, олон нийтэд нээлттэй байх ёстой гэсэн байна.  
[http://osce.org/documents/sg/1994/12/702\\_en.pdf](http://osce.org/documents/sg/1994/12/702_en.pdf)

**Стокхольм дахь Олон улсын энх тайван судлалын хүрээлэнгийн (SIPRI) мэдээллийн сан** нь улс орнуудын цэрэг, батлан

хамгаалахтай холбоотой мэдээллүүдийг агуулдаг. Тус хүрээлэнгийн жил тутмын тайлан хэд хэдэн хэлээр гардаг ба цэргийн зардлын чиг хандлага, зэвсгийн үйлдвэрлэл, шилжүүлгийн талаарх мэдээлэл багтсан байдаг.  
<http://www.sipri.org/about/organization/researchprog/mil-lap>

**НҮБ-ын Цэргийн зардлын тайлан** нь цэргийн зардлын ил тод байдал, зардлыг харилцан бууруулах явдлыг дэмжих зорилготой. НҮБ 1981 оноос хойш цэргийн зардлын тайланг нэг загварын дагуу жил тутам гаргаж ирсэн бөгөөд тайланг дагалдуулан цэргийн асуудлаарх бодит мэдээллийг түгээх, үүний дотор зардлын ил тод байдлыг дэмжихэд чиглэсэн заавар, зөвлөгөө гаргадаг байна.  
<http://www.un.org/disarmament/convarms/Milex/>

**"ВI" – Ёс зүйн өөрийн үнэлгээний процесс** нь НАТО-ын Building Integrity буюу Ёс зүйг бэхжүүлэх хөтөлбөрийн нэг хэсэг юм.



**DCAF**

a centre for security,  
development and  
the rule of law

Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих Женевийн төв (DCAF) аюулгүй байдлын салбарын сайн засаглал, шинэчлэлийг дэмжиж ажилладаг. Тус төв нь орон орны сайн туршлагүүдийг судласны үндсэн дээр үндэсний болон олон улсын зохист хэм хэмжээ бий болгохыг дэмжихийн зэрэгцээ бодлогын зөвлөмж боловсруулж, улс нэг бүрт тухайлсан зөвлөгөө өгч, туслалцааны хөтөлбөр хэрэгжүүлдэг. ЗХАХТЖТ нь улс орны засгийн газар, парламент, иргэний нийгэм, олон улсын байгууллага, зэвсэгт хүчин, цагдаа, шүүх, тагнуул, хил хамгаалах алба зэрэг аюулгүй байдлын салбарын бүхий л байгууллагатай хамтран ажилладаг болно.

Манай байгууллагын цахим хуудас: [www.dcaf.ch](http://www.dcaf.ch)